

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2019 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1.“Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигийг хүчингүйд тооцсугай.

Гарын үсэг

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хууль, тогтоомжид өөрөөр заагаагүй бол “Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх (Цаашид “тангараг өргөх” гэх) ёслол”-ыг зохион байгуулахдаа энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Монгол Улсын иргэн төрийн жинхэнэ албан тушаалд анх томилогдсоны дараа ажил үүргээ гүйцэтгэж эхлэхээс өмнө хуульд заасан тангаргийг өргөнө.

1.3.Энэ журмын 1.2-т заасан тангараг өргөсөн иргэнийг төрийн жинхэнэ албан хаагчид тооцно.

1.4.Давагдашгүй хүчин зүйл болон хүндэтгэн үзэх зайлшгүй шалтгааны улмаас, төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон албан хаагчийг тангараг өргүүлэлгүй албан үүргийг гүйцэтгүүлж эхлүүлсэн бол уг шалтгаан арилмагц нэн даруй өргүүлнэ.

1.5.Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу туршилтын хугацаагаар томилогдсон иргэнийг туршилтын хугацаа дуусахаас өмнө тангараг өргүүлэхгүй.

Хоёр.Тангараг өргөх ёслолын ажиллагааны зохион байгуулалт

2.1.Тангараг өргөх ёслолыг тангараг өргөх албан хаагч (цаашид “Тангараг өргөгч” гэх)-ийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан, түүний эзгүйд тэдгээрийг орлох албан тушаалтан зохион байгуулах үүрэг хүлээнэ. Хэрэв тангараг өргөгч хуульд заасан үндэслэлээр дээд шатны байгууллагаас төрийн жинхэнэ албанд томилогдсон бол түүний томилогдон ажиллах байгууллагын дарга тангараг өргөх ёслолыг зохион байгуулах үүрэгтэй.

2.2.Энэ журмын 2.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон иргэнийг тангараг өргүүлэх тухай шийдвэр гарган ёслолыг хөтлөн явуулах албан тушаалтныг томилно. Тангараг өргөх ёслолын ажиллагааг хөтлөн явуулахаар томилогдсон албан хаагч тухайн ажиллагааны бэлтгэлийг бүрэн хангуулна.

2.3.Тангаргийг хамтаар болон ганцаарчлан өргүүлж болно.

2.4. Тангараг өргөх ёслолд тухайн байгууллагын нийт албан хаагчид эсвэл тангараг өргөгчийн ажиллах бүтцийн нэгжийн албан хаагчдаас байлцуулах бөгөөд тангараг өргөгчийн ажиллах байгууллагын дарга болон тангараг өргөгчийг харьяалах нэгжийн дарга, түүний эзгүйд тэдгээрийг орлох албан тушаалтны аль нэг заавал оролцоно. Шаардлагатай гэж үзвэл төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, хэвлэл, мэдээллийн байгууллага, иргэдийн төлөөлөгчдийг оролцуулж болно.

2.5. Тангараг өргөх байранд Монгол Улсын Төрийн сүлд, түүний баруун гар талд Төрийн далбааг байрлуулна.

2.6. Энэ журмын 3.2-т заасан тангарагийн батламж хуудасны гарын үсгээс бусад хэсгийг бөглөж бэлтгээд тусгайлан зассан ширээн дээр тавьсан байна.

2.7. Тангараг өргөгч Монгол Улсын Төрийн сүлд рүү харан цэх зогсоно. Хамтаар өргөх бол эгнэн зогсоно.

2.8. Тангараг өргөх ёслолыг хөтлөн явуулах албан хаагч тангараг өргүүлэх тухай шийдвэрийг уншиж тангараг өргөгчийг танилцуулна.

2.9. Тангараг ганцаарчлан өргөгч тангаргийн үгийг ёслолд оролцогчдод дуулдахуйц тод дуугаар, хамтаар өргөж байгаа бол тангараг өргөж байгаа бүрэлдэхүүний насаар ахмад албан хаагч бусдад дуулдахуйц тод дуугаар уншихад бусад албан хаагч давтана.

2.10. Тангараг өргөсний дараа тангараг өргөгч Монгол Улсын Төрийн сүлдэнд ёсолж хүндэтгээд зүүн өвдөг сөхрөн Төрийн далбаанаас адис авна.

2.11. Тангараг өргөгч тангаргийн батламжийн хуудсыг уншиж танилцаад гарын үсэг зурна.

2.12. Тангаргийн батламжид тангараг өргөх ёслолыг зохион байгуулсан албан тушаалтан гарын үсэг зурна.

2.13. Тангаргийн батламжид байгууллагын тамга дарж баталгаажуулна.

2.14. Тангараг өргөх ёслолыг зохион байгуулсан албан тушаалтан тангараг өргөсөн албан хаагчид баяр хүргэж үг хэлнэ.

2.15. Үг хэлж дууссаны дараа төрийн дууллыг эгшиглүүлнэ. Энэ үед тангараг өргөх ёслолд оролцогчид босож хүндэтгэнэ.

Гурав. Тангаргийн батламж

3.1.Тангаргийн батламж нь төрийн жинхэнэ албан хаагч тангараг өргөснийг баталсан албан ёсны баримт мөн.

3.2.Тангаргийн батламж хуудас нь нүүрэн талдаа Монгол Улсын төрийн сүлдийг дүрсэлж, түүний дор "Монгол Улсын төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг" гэж бичсэн байна.

Ар талдаа "Эх орон, ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, Монгол Улсын хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан албан үүргээ үнэнч шударгаар биелүүлэхээ тангараглая. Тангаргаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ" гэж үргэлжлүүлэн бичсэн байна.

Түүний дор тангараг өргөгчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, томилогдсон болон тангараг өргүүлэх шийдвэрийн огноо, дугаар, тангараг өргөх ёслолыг зохион байгуулсан албан тушаалтны нэр, албан тушаал, тангараг өргөгч болон ёслолыг зохион байгуулсан албан тушаалтан гарын үсэг зурах, байгууллагын тамга дарах, тангараг өргөсөн огноог бичих хэсэг байна.

3.3.Тангаргийн батламж тус бүр дугаар, нууцлалын кодтой байна. Дугаар, кодыг давхардуулж болон алгасуулж олгохгүй. Тангаргийн дугаар, нууцлалын кодыг Төрийн албаны төв байгууллага хөтлөнө.

3.4.Төрийн жинхэнэ албан хаагчийн тангаргийн батламжийн загварыг Төрийн албаны төв байгууллага батална.

Дөрөв. Бусад зүйл

4.1.Тангараг өргөсөн албан хаагчийн хувийн хэрэгт тангаргийн батламжийн эх хувийг болон тангараг өргүүлэх тухай шийдвэрийн хуулбарыг хадгална.

4.2.Энэ журамд заасан ёслолын үйл ажиллагаанаас гадна төрийн тусгай албаны онцлогийг тусгасан ёслол, хүндэтгэлийн шинж чанартай зан үйлийг нэмэлт байдлаар энэ журамд нийцүүлэн зохион байгуулж болно.

4.3.Төрийн жинхэнэ албан хаагч төрийн жинхэнэ албанахаас бусад албан тушаалд сонгогдон буюу томилогдон ажилласны дараа төрийн жинхэнэ албан тушаалд эргэн томилогдвол дахин тангараг өргөнө.

4.4.Төрийн захиргаа болон төрийн тусгай алба хооронд эсвэл төрийн тусгай албад хооронд шилжин ажиллах тохиолдолд тангаргийг сүүлд томилогдсон салбарын үгээр шинэчлэн өргөнө. Харин төрийн жинхэнэ алба дотор шилжин ажилласны дараа

эргэн өмнө ажиллаж байсан албанд томилогдсон тохиолдолд энэ журмын 4.3 дахь заалтад хамаарахгүй бол дахин тангараг өргөхгүй.

4.5. Тангаргийн үг өөрчлөгдсөн тохиолдолд тангаргийг шинэчлэн өргүүлэх ажлыг эрх бүхий албан тушаалтан тухай бүр зохион байгуулна

Тав. Хариуцлага

5.1. Энэ журмыг зөрчсөн тухай гомдлыг Төрийн албаны зөвлөлд гаргана.

5.2. Хэрэв энэ журмын 2.1-д заасан албан тушаалтан үүргээ үл биелүүлэн иргэнийг тангараг өргүүлээгүй бол түүнд Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

5.3. Энэ журмын 5.2-т заасан шалтгаанаар иргэнийг тангараг өргүүлээгүй нь уг иргэн төрийн жинхэнэ албан хаагч болоход саад болохгүй.

5.4. Хэрэв тухайн иргэн төрийн жинхэнэ албанд хууль бусаар томилогдсон болох нь тогтоогдсон бол тухайн иргэний тангаргийн батламжийг хүчингүйд тооцно. Ийнхүү хүчингүйд тооцсон талаар тангаргийн батламжийн бүртгэлд тухай бүр тусгана.

--- оОо ---

ЖУРМЫН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

.....
.....

